



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/67

Есөнбулаг

Д.Мөнхбаатарын сургалтын төлбөрт  
дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинжлэх ухаан техникийн их сургуулийн барилга, архитекторын ангийн оюутан Д.Мөнхбаатарын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан эх үүсвэрээс гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

